



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 383

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага “Хүнсний ногооны үйлдвэрлэл, зах зээлийн гарцыг нэмэгдүүлж, эдийн засгийг дэмжих төсөл”-өөс шилжүүлсэн, 187,562,805.90 (нэг зуун наян долоон сая таван зуун жаран хоёр мянга найман зуун таван төгрөг ерэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 36,702,960.30 (гучин зургаан сая долоон зуун хоёр мянга есөн зуун жаран төгрөг гучин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийд балансад шилжүүлсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг авто тээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123001648
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн
дугаар тогтоогийн хавсралт

**НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛАГЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛАГЫН
ХҮНСНИЙ НӨГООНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН ГАРЦЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр, марк, улсын дугаар, км гүйлт	Арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ элэгдэл	Хууримтлагдсан (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	Тээврийн хэрэгсэл (Ланд круизер 300 Station Wagon маркийн 9936 ДК улсын дугаартай, 29572 км гүйлттэй)	JTMACBVJ9 04050669	2023.11.08	187,562,805.90	36,702,960.30	150,859,845.60	Хөдөө аж ахуйн корпораци төрийн өмчийт хязгаарлагдмал хариуцлагатай компани
	Нийт дүн			187,562,805.90 (Нэг зуун наян долоон сая таван зуун жаран хоёр мянга найман зуун таван төгрөг өрэн мөнгө)	36,702,960.30 (гучин зургаан сая долоон зуун хоёр мянга есэн зуун жаран төгрөг гучин мөнгө)	150,859,845.60 (нэг зуун тавин сая найман зуун тавин есэн мянга найман зуун дөчин таван төгрөг жаран мөнгө)	